

Монгол улсын нийслэл

УЛААНБААТАР ХОТ




НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР

2012 он

Монгол улсад хүн амын өсөлтөөр Улаанбаатар хот бусад бүс нутаг, аймаг, хоттой харьцуулахад “хэмжээлшгүй” том засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болсоор байна.

Зураг 1. Монгол улсын хүн амд бүс нутгийн хүн амын эзлэх хувийн жин.



Улаанбаатар хотод 2012 оны эхэнд Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 45.8 хувь буюу 1,206.6 мянган хүн байнга оршин сууж байна.

Хүснэгт 1. Хүн амын тоо, мянган хүн

	2010 он	2011 он
Монгол улсын хүн ам	2,761.0	2,811.6
Үүнээс Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн ам	2,653.8	2,704.5
Улаанбаатар хотын хүн ам	1,244.4	1,287.1
Үүнээс Улаанбаатар хотын суурин хүн ам	1,161.8	1206.6

Улаанбаатар хотын хүн ам 1956 онд улсын нийт хүн амын 14.0 хувийг эзэлж байсан бол 1969 онд 22.3 хувь, 2010 онд 43.6 хувьд хүрсэн байв.

Монгол Улсын хотын хүн амын дийлэнх буюу 64.2 хувь зөвхөн Улаанбаатар хотод амьдарч байна. Үүний дараа Эрдэнэт, Дархан хот орж, бусад хот, суурин газарт хотын хүн амын 26.9 хувь нь оршин сууж байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээс харахад дийлэнх аймгийн хүн амын тоо буурч, улсын дүнд эзлэх хувийн жин нь багасч байхад Улаанбаатарынх эрчимтэй өсчээ. Монгол улсын хүн амын дотоод шилжилт хөдөлгөөн Улаанбаатар руу чиглэсэн хэвээр байна.

Манай улсын хамгийн их хүн амтай Хөвсгөл аймгаас 5-аас 168 мянгаар илүү хүн ам нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт тус тус байнга оршин сууж байна.

Зураг 2. Суурин хүн амын тоо, аймаг, дүүргээр
2012 оны эхэнд, мянган хүнээр



Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт нийслэлийн нийт хүн амын тал шахам, улсын хүн амын 20 шахам хувь нь амьдарч байна.

Зураг 3. Хүн амын нягтрал, аймаг, нийслэлээр,
2010 оны ХАОСТ-ын дүнгээр



Улаанбаатар хот хүн амын нягтрал Монгол улсад хамгийн өндөр хэвээр байна.

Улаанбаатар хот Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзэлдэг. Манай хотын нэг квадрат километр нутаг дэвсгэрт 2000 онд 162 хүн ногдож байснаа 2010 онд 246 болж, 2012 оны 262 хүн болж өсчээ.

Зураг 4. Хүн амын нягтрал, 2011 он




Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн хүн амын нягтрал нь нэг км кв нутаг дэвсгэрт ногдох хүний тоогоор дэлхийд хамгийн өндөрт тооцогддог улс, суурин газруудтай харьцуулагдах түвшинд хүрчээ.

Улаанбаатар хотод улсын хүн амын дийлэнх төвлөрч байгаа нь манай хотын хүн амын бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт, хэрэгцээг нэмэгдүүлж, тэр хэрээр эдийн засгийн үйл ажиллагааг өргөжүүлэх боломжийг бий болгож байна.

Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын 70.0 хувь, үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 64.2 хувь нь нийслэл хотод байршдаг.

Зураг 5. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо, бүс нутгаар



Нийслэл хотод үйл ажиллагаа явуулахаар 47,195 аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлсэн байна. Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын 65.4 хувь буюу 30866 нь жилийн турш байнгын үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 6. Үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн улсын дүнд эзлэх хувь, эдийн засгийн салбараар




Монгол улсад үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн 83 хувь, тээвэр, холбооны салбарын ААН-ийн 80 хувь, барилгын нийт ААН-ийн 80 хувь нь тус тус нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байна.

Нийслэлийн эдийн засгийн 68.8 хувийг үйлчилгээний, 30.7 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 0.4 хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлдэг. Нийслэлийн эдийн засагт бөөний болон жижиглэн худалдаа, боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, олборлолт, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа хамгийн их эзлэх хувийн жинтэй байна.

Монгол улсын 2011 оны дотоодын нийт бүтээгдэхүүний 65 хувийг нийслэл хот бүрдүүлжээ. Нийслэл хотын эдийн засаг 2011 оны үнээр 7,193.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 38.4 хувиар өссөн байна.


Зураг 7. ДНБ-д бүс нутгийн эзлэх хувь.



Улаанбаатараас бусад бүсийн ДНБ-д эзлэх хувийн жин 2011 онд 3.4-17.0 хувь байгаа нь 2010 оныхоос 0.1-2.1 пунктээр буурсан байна.

Нийслэлийн нэг хүнд ногдох нэмүү өртөг 2011 онд 5.7 сая төгрөг болж, өмнөх оныхоос 1.4 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь улсын дунджаас 1.8 сая төгрөгөөр илүү байна. Монгол улсын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2011 онд 3.9 сая төгрөг болж, 2010 оноос 906.8 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Зураг 8. Нэг хүнд ногдох нэмүү өртөг, мянган төгрөгөөр, 2011 он



Улаанбаатар хотод дэд бүтэц, зах зээлийн хүчин чадавх, мэргэжилтэй ажиллах хүчний төвлөрөл ихтэйгээс нийт хөрөнгө оруулалтын 60 гаруй хувь нь нийслэлд зарцуулагдаж байна. Харин хөдөө нутагт дэд бүтцийн хөгжил сул, зах зээл бага, зах зээлээс алслагдмал, ихэнх хүн ам нь мал аж ахуйгаас хараат тул хөрөнгө оруулалт нийслэлтэй харьцуулахад бага юм.

Нийслэл хотын эдийн засагт 2011 онд 3,874.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Хөрөнгө оруулалтын хэмжээ 2010 оныхоос 2.2 дахин буюу 2,095.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт хөрөнгө оруулалтын 49.5 хувийг гадаадын, 50.5 хувийг дотоодын хөрөнгө оруулалт эзэлж байна. 2011 онд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оноос 48.9 хувиар, дотоодын хөрөнгө оруулалт бараг 4 дахин өсчээ.

Нийслэлийн аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн 2011 онд 2,433.1 тэрбум төгрөг болж, 2,924.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь 2010 онтой харьцуулбал үйлдвэрлэлт 27.1 хувиар, борлуулалт нь 33.7 хувиар тус тус өссөн байна. Нийт борлуулалтын 1,251.6 тэрбум төгрөгийг дотоодод, 1,672.7 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Манай улсын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтын 52.0 хувийг нийслэлийн аж үйлдвэрийн салбарын борлуулалт эзэлж байна.

Улсын боловсруулах аж үйлдвэрийн салбарын дүнд нийслэлийн салбарын үйлдвэрлэлт 42.2 хувийг эзэлж байна.

Монгол улсын 2011 оны барилга угсралт, их засварын нийт 745.0 тэрбум төгрөгийн ажлын 75.4 хувь нь нийслэл хотод хийгдсэн байна. Нийслэлд 420 гаруй аж ахуй нэгж байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж, нийт 561.6 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь өмнөх оноос 1.7 дахин өсчээ.

Хүснэгт 2. Барилга угсралт, их засварын ажил, тэрбум төгрөг

	2008 он	2009 он	2010 он	2011 он
Баруун бүс	45.2	43.9	52.9	71.8
Хангайн бүс	60.9	34.1	38.6	57.4
Төвийн бүс	21.6	21.2	24.8	31.2
Зүүн бүс	9.5	8.8	11.2	13.2
Улаанбаатар	318.7	261.9	309.1	473.7
дүн	479.6	373.6	442.7	657.2

Нийслэл хотод 2011 онд нийт 519.9 тэрбум төгрөгийн барилгын өртөг бүхий 448 барилга объект ашиглалтад оруулсан бөгөөд барилгыг өмчлөлийнх нь хувьд авч үзвэл төрийн өмчийн 20 хувь, хувь иргэний 15 хувь, хувийн хуулийн этгээдийн 65 хувь тус тус байна.


Монгол улсын бөөний болон жижиглэн худалдааны нийт борлуулалт 2011 онд 6793.6 тэрбум төгрөг болов. Улсын худалдааны нийт борлуулалтын 75.1 хувь буюу 5099.8 тэрбум төгрөгийн борлуулалт нийслэл хотод дангаараа хийгджээ.

Авто тээврээр улсын хэмжээнд 2011 онд тээвэрлэсэн нийт зорчигчдын 80.4 хувь, тээсэн нийт ачааны 12.0 хувь нь нийслэл хотод тус тус ногдож байна.

Улаанбаатар хотод ажлын байр найдвартай олддог нь хүмүүсийг ихээр татаж, төвлөрөл улам бүр нэмэгдэж байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн ам улсын хэмжээнд 2011 онд 1,124.7 мянга болсны 34.0 хувь, хөдөлмөр эрхэлж буй 1,037.7 мянган хүний 34.8 хувь нь тус тус нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна.

Зураг 9. УБ хотын ажил эрхлэлтийн байдал, улсын дүнд эзлэх хувь, 2011 он




Эдийн засгийн үйл ажиллагааны бүх төрлийн салбарт ажиллагсдын тоо 2004 онд 322.7 мянга, 2005 онд 333.7 мянга, 2006 онд 359.4 мянга, 2007 онд 368.7 мянга, 2008 онд 391.9 мянга байсан бол "Ажиллах хүчний судалгаа"-ны дүнгээр 2009 онд 333.8 мянга, 2010 онд 360.9 мянга, 2011 онд 361.4 болжээ.

2000 онд Улаанбаатар хотод шилжин ирэгчдийг их шингээдэг салбар нь боловсруулах үйлдвэр, зочид буудал, зоогийн газар байсан бол 2010 онд хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбар болж өөрчлөгдсөн байна.

Энэ нь Улаанбаатар хотын чинээлэг давхаргад үзүүлэх үйлчилгээ улам бүр өргөжиж Улаанбаатар хотын захын хороололд хүмүүс шилжин ирээд мал маллаж эсвэл газар тариалан эрхэлж амьдрах болсон.


Зураг 10. Ажилгүйдлийн түвшин, бүс нутгаар



2011 оны байдлаар “Ажиллах хүчний судалгаа”-ны дүнгээр тооцсон ажилгүйдлийн түвшин Завхан аймагт хамгийн өндөр буюу 18.2 хувь, Сэлэнгэ аймагт хамгийн бага буюу 1.4 хувь, улсын дундаж 7.7 хувь байгаа бол нийслэлийн хувьд 5.6 хувьтай байна.

Хотын ядуурал нь ажилгүйдлээс бүс бүрэн бүс ажил эрхлэлтээс илүү шалтгаалсан байдаг. Улаанбаатар хотын ядуурал нь жил бүр нэмэгдэж 2010 оны судалгаагаар нийслэл хотын хүн амын 29.8 хувь нь ядуу амьдарч байв. 2011 оны өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаагаар нийслэл хотын нийт хүн амын 23.5 хувь нь ядуурлын шугамнаас дунджаар 5.9 хувиар доогуур хэрэглээтэй байна.

Зураг 11. Ядуурлын хамралтын хувь



Ядуурлын хамралтын хүрээ 2011 онд өмнөх жилээс буурсан нь Монгол улсын иргэн бүрт “эх орны хишиг” олгож жилийн турш байнгын орлоготой байсан, байнгын ажлын байрны тоо нэмэгдсэнтэй холбоотой юм.

Нийслэл хотод ядуурлын хамралтын хүрээ 2011 онд төв, баруун, зүүн, хангайн бүс нутагтай харьцуулахад 3.7-15.4 пунктээр, улсын дунджаас 6.3 пунктээр тус тус доогуур байна.

Улаанбаатар хот - Монгол улсын улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын гол төв төдийгүй хүн ам, эдийн засгийн бараг бүх үйл ажиллагааны салбарын дийлэнх хувийг илэрхийлж чадах засаг захиргааны нэгж болжээ.

Зураг 12. Төвлөрөл, хувиар



Монгол улсын нийт хүн амын 46 шахам хувь, аж ахуйн нэгж, байгууллагын 64 хувь зөвхөн Улаанбаатар хотод суурьшиж байгаагаас иргэдийн хадгаламж, банкны зээл, автомашин, их эмчийн ихэнхи хувь нь бас ногдож байна. Нийслэлд хотод манай улсын их дээд сургуулиудын 92 хувь нь байршиж, түүнд нийт оюутан сурагчдын 89 хувь нь суралцаж байна.

Хүснэгт 3. Хүн амын боловсролын түвшний индекс

	2008 ОН	2009 ОН	2010 ОН	2011 ОН
Улсын дундаж	0.916	0.921	0.928	0.933
Баруун бүс	0.933	0.937	0.942	0.947
Хангайн бүс	0.909	0.914	0.918	0.914
Төвийн бүс	0.917	0.920	0.924	0.934
Зүүн бүс	0.904	0.907	0.909	0.914
Улаанбаатар	0.916	0.922	0.929	0.940

Хүний хөгжлийн индексээр Улаанбаатар бүсийнх 0.797 болж улсын болон бусад бүс нутгийнхтай харьцуулахад өндөр байна.

Тухайлбал, Монгол улсад хүн эрүүл саруул байж, урт удаан наслах, эрдэм мэдлэг эзэмших, амьжиргааны зохистой нөхцөлд аж төрөх гэсэн хүний амьдралын үндсэн 3 хэмжигдэхүүн Улаанбаатар хотын хувьд бусад аймаг, бүс нутгаас илүү байна.

Хүснэгт 4. Хүний хөгжлийн индекс

	2008 он	2009 он	2010 он	2011 он
Улсын дундаж	0.745	0.750	0.756	0.769
Баруун бүс	0.710	0.703	0.697	0.712
Хангайн бүс	0.745	0.744	0.747	0.754
Төвийн бүс	0.727	0.732	0.735	0.755
Зүүн бүс	0.706	0.709	0.706	0.719
Улаанбаатар	0.761	0.770	0.776	0.797

Ялангуяа нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний индекс буюу амьжиргааны зохистой түвшин 0.709 болж, улсын болон бусад бүс нутгаас нилээд өндөр байна.

Хүснэгт 5. Нэг хүнд ногдох ДНБ-ий индекс

	2008 он	2009 он	2010 он	2011 он
Улсын дундаж	0.615	0.614	0.623	0.651
Баруун бүс	0.506	0.469	0.445	0.465
Хангайн бүс	0.637	0.617	0.623	0.635
Төвийн бүс	0.550	0.551	0.553	0.586
Зүүн бүс	0.529	0.522	0.511	0.525
Улаанбаатар	0.658	0.666	0.678	0.709

Хүснэгт 6. Хүн амын дундаж наслалтын индекс

	2008 он	2009 он	2010 он	2011 он
Улсын дундаж	0.704	0.716	0.718	0.722
Баруун бүс	0.691	0.704	0.705	0.724
Хангайн бүс	0.688	0.700	0.701	0.713
Төвийн бүс	0.714	0.726	0.727	0.745
Зүүн бүс	0.686	0.698	0.699	0.718
Улаанбаатар	0.708	0.721	0.722	0.741

Амьжиргааны зохистой түвшин рүү чиглэсэн хүн амын хэт төвлөрөл нь нийгмийн болон нийтийн үйлчилгээний хэт ачааллыг бий болгож байна. Энэ хэт ачааллаас үүдэлтэй нь хөрсөн бүрхэвч, усан орчин, агаарын чанарын бохирдол, хог хаягдал зэрэг нь Улаанбаатар хотын оршин суугчдын амьдралын тав тухтай, таатай орчинд сөргөөр нөлөөлж улмаар хүний хөгжлийг хангах боломжийг хязгаарлагч хүчин зүйл болжээ.

Хүснэгт 7. 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо

	2008 он	2009 он	2010 он	2011 он
Баруун бүс	78	67	67	64
Хангайн бүс	71	65	69	66
Төвийн бүс	130	118	107	99
Зүүн бүс	122	115	106	100
Улаанбаатар	158	155	141	132
Улсын дундаж	122	116	109	103

Нийслэл хотын эдийн засаг 7 их наяд төгрөгийн хэмжээтэй болсон ч хотын төсөв түүний 5 орчим хувьтай тэнцэж байна.

Хотын хүн амыг ундны цэвэр ус, цахилгаан, дулаанаар хангаж буй өнөөгийн үйл ажиллагаа, төсөв хөрөнгийн хомсдол нь бохирдол, хог хаягдал үүсэх үндсэн нөхцөл, шалтгаан болж байна.

Агаар дахь бохирдуулагч бодисын агууламжийн хүлцэх хэм хэмжээний стандарт Улаанбаатар хотод хамгийн ихээр хэтэрсэн байна.

Зураг 13. Агаар дахь хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж, мг\м³



Зураг 14. Агаар дахь азотын давхар ислийн жилийн дундаж агууламж, мг\м³



Эрүүл мэнд, сургууль, аж үйлдвэр, санхүүгийн үйл ажиллагаа, өндөр орлоготой хүмүүсийн төвлөрлөөс харахад Монгол Улсын эдийн засагт Улаанбаатар хотын гүйцэтгэх үүрэг асар их бөгөөд өнөөгийн хөгжлийн түвшин нь ойрын хэдэн жилдээ дотоод шилжих хөдөлгөөний эцсийн хүрэх цэг хэвээр байх болно.